# ДУНДГОВЬ АЙМГИЙН
# САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 03 өдөр Дугаар А/84 Онги

Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран өмчилсөн газрыг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сайхан-овоо сумын гэр хороололд 2008 оны 05 дугаар сарын 01-нээс өмнө гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан газар нэг удаа үнэгүй өмчилж гэр бүлийн гишүүд нэгэндээ газар өмчлөх эрхээ шилжүүлсэнтэй холбогдуулж газар өмчлөх эрх шилжүүлж авсан 1 иргэний нэр, газрын байршил, хэмжээ, үнэлгээг хавсралтаар баталсугай.

2.Аймгийн хэмжээнд 2008 онд кадастрын зураглал хийгдсэнтэй холбогдуулан зарим иргэдийн газрын хэмжээг зурагт орсноор өөрчлөн шилжүүлэх, газар өмчлөгчийн хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн (Т.Саранзул)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2008 оны 18 дугаар захирамжийн хавсралтын 19 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4.Хамтран өмчлөх эрхээсээ татгалзсан иргэдэд хууль тогтоомжид заасны дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА Г.ЛУВСАНРАГВА

Засаг даргын 2023 оны ..11..дүгээр сарын..03..ны өдрийн
А/24 дугаар захирамжийн хавсралт

| № | Газар өмчлөх эрх шилжүүлж авсан иргэн | | | | Газар өмчлөх эрх шилжүүлсэн | | Газрын байршил | Газрын хэмжээ /м2/ | Газрын үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Овог | Эцэг /эх/-ийн нэр | Нэр | Регистр | Овог нэр | Регистр | | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | Харлаг | Оросоо | Наранбаатар | ЗЛ75101813 | Б.Уранбайгаль | ЗП64041200 | Хаданхошуу 6-600 | 1824 | 1459200 |
| | | | | | Н.Баярсайхан | ЗК92110110 | | | |
| | | | | | Н.Дөлгөөнсайхан | ЗЛ05292412 | | | |